ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2022/186/НА-СТА-ТШЗ


Хөвсгөл аймаг дахь Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ
Утас: 261628 Цахим хаяг:
Ахлах аудитор: С.Гансүх
Утас: 95908400 Цахим хаяг: gansukhsa@audit.gov.mn
Ньюбаланс Аудит ХХК-ийн
Захирал: Цахим хаяг : newbalance.lhagvaa@gmail.com
Утас: 99101901
Чанарын хяналтын менежер: Д.Гэрэлчулуун d.gerlee98@gmail.com
Аудиторын туслах: Д.Балжинням d.baljii73@gmail.com
Утас: 86267997



Цахим хуудас: www.audit.mn
Хөвсгөл аймаг
2022 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 11
3. Аудитын тайлан ........ 11
3.1 Ерөнхий зүйл ........ 11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 12
3.4 Материаллаг байдал ........ 12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 14
3.8 Аудитын гол асуудал ........ 15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 15
4. Аудитын илрүүлэлт ........ 15
4.1 Залруулсан алдаа ........ 15
4.2 Төлбөрийн акт ........ 16
4.3 Албан шаардлага ........ 16
4.4 Зөвлөмж ........ 16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/220
танай ______ -ны № / ______ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Н.ЦЭЦЭГМАА ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **127,673,804.13** | **147,674,290.10** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 127,673,804.13 | 147,674,290.10 |
| **351** | **Түүхий эд материал** | 6,672,700.00 | 4,267,733.00 |
| 35130 | Эм боох материал | 6,672,700.00 | 4,267,733.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 121,001,104.13 | 143,406,557.10 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,591,076.00 | 6,957,476.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 36,972,840.50 | 44,173,740.50 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 9,762,000.00 | 4,216,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 5,753,670.00 | 10,141,170.00 |
| 35460 | Хүнсний материал | 6,802,605.03 | 6,695,358.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 60,118,912.60 | 71,222,812.60 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **672,256,286.73** | **656,022,212.60** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 672,256,286.73 | 656,022,212.60 |
| **392** | **Биет хөрөнгө** | 657,776,886.73 | 641,542,812.60 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 639,024,700.00 | 639,024,700.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -27,349,563.12 | -41,024,344.68 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 57,468,017.00 | 46,814,825.08 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -38,434,110.23 | -28,584,267.79 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 24,669,017.80 | 20,832,306.30 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -16,263,396.94 | -11,984,475.01 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 58,033,114.00 | 50,556,834.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -42,435,575.48 | -37,157,449.00 |
| 39217 | Ном | 3,064,683.70 | 3,064,683.70 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 14,479,400.00 | 14,479,400.00 |
| 39301 | Програм хангамж | 1,012,000.00 | 1,012,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,012,000.00 | -1,012,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 14,479,400.00 | 14,479,400.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **799,930,090.86** | **803,696,502.70** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **2,550,039.97** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 2,550,039.97 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 2,550,039.97 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 2,550,039.97 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **799,930,090.86** | **801,146,462.73** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 799,930,090.86 | 801,146,462.73 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 168,390,133.00 | 168,390,133.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 168,390,133.00 | 168,390,133.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 615,017,857.86 | 616,234,229.73 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 615,017,857.86 | 615,017,857.86 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 1,216,371.87 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 16,522,100.00 | 16,522,100.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **799,930,090.86** | **803,696,502.70** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **458,572,100.00** | **423,622,223.58** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,248,500.00** | **405,634,990.58** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 5,248,500.00 | 8,173,190.58 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 5,248,500.00 | 8,173,190.58 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 5,248,500.00 | 8,173,190.58 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 00.00 | 397,461,800.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 00.00 | 397,461,800.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **17,681,800.00** | **17,987,233.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 435,641,800.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 305,433.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 305,433.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 17,681,800.00 | 17,681,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 17,681,800.00 | 17,681,800.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **435,142,871.66** | **422,302,363.71** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **435,142,871.66** | **422,302,363.71** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 427,067,096.66 | 421,935,606.93 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 309,278,521.00 | 305,920,083.19 |
| 210101 | Үндсэн цалин | 253,572,592.60 | 196,672,823.92 |
| 210102 | Нэмэгдэл | 34,014,303.40 | 85,286,219.30 |
| 210104 | Урамшуулал | 21,691,625.00 | 23,961,039.97 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 41,815,299.00 | 41,003,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,334,200.00 | 28,854,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,120,300.00 | 3,037,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,496,200.00 | 2,429,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 624,100.00 | 607,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,240,499.00 | 6,074,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,369,120.00 | 15,846,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,000,000.00 | 1,000,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 3,489,120.00 | 13,482,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,880,000.00 | 1,364,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,941,950.00 | 6,651,400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,615,450.00 | 2,408,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,000,000.00 | 2,833,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 388,100.00 | 487,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 800,900.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,137,500.00 | 921,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 27,786,790.00 | 24,496,747.03 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 260,000.00 | 2,817,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 27,526,790.00 | 21,679,247.03 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,570,500.00 | 4,226,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,570,500.00 | 4,226,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 224,000.00 | 267,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 224,000.00 | 267,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,150,900.00 | 540,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 800,900.00 | 00.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 350,000.00 | 540,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 23,930,016.66 | 22,983,776.71 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 837,700.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 681,500.00 | 100,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 22,410,816.66 | 22,883,776.71 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 8,075,775.00 | 366,756.78 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 600,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 600,000.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 7,475,775.00 | 366,756.78 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,475,775.00 | 366,756.78 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **23,429,228.34** | **1,319,859.87** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 103,488.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 103,488.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -103,488.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **23,429,228.34** | **1,216,371.87** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **168,390,133.00** | **16,522,100.00** | **615,017,857.86** | **799,930,090.86** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **168,390,133.00** | **16,522,100.00** | **615,017,857.86** | **799,930,090.86** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 1,216,371.87 | 1,216,371.87 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **168,390,133.00** | **16,522,100.00** | **616,234,229.73** | **801,146,462.73** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **453,323,600.00** | **415,449,033.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **397,461,800.00** |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 00.00 | 397,461,800.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 00.00 | 397,461,800.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **453,323,600.00** | **17,987,233.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 435,641,800.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 305,433.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 305,433.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 17,681,800.00 | 17,681,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 17,681,800.00 | 17,681,800.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **445,566,150.00** | **411,869,033.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **445,566,150.00** | **411,869,033.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **437,490,375.00** | **411,502,276.22** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 309,278,520.00 | 303,370,043.22 |
| 210101 | Үндсэн цалин | 253,572,591.60 | 196,672,823.92 |
| 210102 | Нэмэгдэл | 34,014,303.40 | 85,286,219.30 |
| 210104 | Урамшуулал | 21,691,625.00 | 21,411,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 41,815,300.00 | 41,003,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 29,334,200.00 | 28,854,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,120,300.00 | 3,037,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,496,200.00 | 2,429,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 624,100.00 | 607,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,240,500.00 | 6,074,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 15,500,000.00 | 10,300,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,000,000.00 | 1,000,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 7,920,000.00 | 7,936,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,580,000.00 | 1,364,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 17,331,500.00 | 14,810,233.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 588,100.00 | 321,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,000,000.00 | 2,833,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 338,100.00 | 487,800.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 281,800.00 | 267,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,420,000.00 | 305,433.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 9,703,500.00 | 10,594,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 44,834,605.00 | 22,750,500.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,812,700.00 | 107,100.00 |
| 210502 | Хоол, хүнс | 30,174,805.00 | 21,572,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,847,100.00 | 1,071,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,181,800.00 | 9,942,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 2,561,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,181,800.00 | 7,381,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 224,000.00 | 267,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 224,000.00 | 267,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,100,900.00 | 968,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 800,900.00 | 428,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 540,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,223,750.00 | 8,089,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 845,400.00 | 803,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,378,350.00 | 7,285,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **8,075,775.00** | **366,756.78** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 600,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 600,000.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 7,475,775.00 | 366,756.78 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,475,775.00 | 366,756.78 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **7,757,450.00** | **3,580,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **7,757,450.00** | **3,580,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **7,757,450.00** | **3,580,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 7,757,450.00 | 3,580,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 7,757,450.00 | 3,580,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-7,757,450.00** | **-3,580,000.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 415,143,600.00 | 414,776,843.22 | 366,756.78 | 99.9 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 415,143,600.00 | 414,776,843.22 | 366,756.78 | 99.9 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 415,143,600.00 | 414,776,843.22 | 366,756.78 | 99.9 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 303,727,800.00 | 303,370,043.22 | 357,756.78 | 99.9 |
| 210101 | Үндсэн цалин | 179,807,300.00 | 199,508,188.92 | -19,700,888.92 | 111.0 |
| 210102 | Нэмэгдэл | 102,509,500.00 | 82,450,854.30 | 20,058,645.70 | 80.4 |
| 210104 | Урамшуулал | 21,411,000.00 | 21,411,000.00 | 00.00 | 100.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 41,003,100.00 | 41,003,100.00 | 00.00 | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28,854,100.00 | 28,854,100.00 | 00.00 | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,037,200.00 | 3,037,200.00 | 00.00 | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,429,800.00 | 2,429,800.00 | 00.00 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 607,400.00 | 607,400.00 | 00.00 | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,074,600.00 | 6,074,600.00 | 00.00 | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 10,300,000.00 | 10,300,000.00 | 00.00 | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,000,000.00 | 1,000,000.00 | 00.00 | 100.0 |
| 210302 | Түлш, халаалт | 8,000,000.00 | 7,936,000.00 | 64,000.00 | 99.2 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,300,000.00 | 1,364,000.00 | -64,000.00 | 104.9 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16,624,800.00 | 16,624,800.00 | 00.00 | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 321,400.00 | 321,400.00 | 00.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,000,000.00 | 2,833,600.00 | 166,400.00 | 94.5 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 321,400.00 | 487,800.00 | -166,400.00 | 151.8 |
| 210404 | Ном, хэвлэл | 267,800.00 | 267,800.00 | 00.00 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,714,200.00 | 12,714,200.00 | 00.00 | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 22,750,500.00 | 22,750,500.00 | 00.00 | 100.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 107,100.00 | 107,100.00 | 00.00 | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 21,572,000.00 | 21,572,000.00 | 00.00 | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,071,400.00 | 1,071,400.00 | 00.00 | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,411,800.00 | 11,402,800.00 | 9,000.00 | 99.9 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,030,000.00 | 4,021,000.00 | 9,000.00 | 99.8 |
| 210604 | Урсгал засвар | 7,381,800.00 | 7,381,800.00 | 00.00 | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 267,800.00 | 267,800.00 | 00.00 | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 267,800.00 | 267,800.00 | 00.00 | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 968,500.00 | 968,500.00 | 00.00 | 100.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 428,500.00 | 428,500.00 | 00.00 | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 540,000.00 | 540,000.00 | 00.00 | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8089300.00 | 8089300.00 | 00.00 | 100.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 803,900.00 | 803,900.00 | 00.00 | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,285,400.00 | 7,285,400.00 | 00.00 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 415,143,600.00 | 414,776,843.22 | 366,756.78 | 99.9 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 397,461,800.00 | 397,095,043.22 | 366,756.78 | 99.9 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 397,461,800.00 | 397,095,043.22 | 366,756.78 | 99.9 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 17,681,800.00 | 17,681,800.00 | 00.00 | 100.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 17,681,800.00 | 17,681,800.00 | 00.00 | 100.0 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 00.00 | - |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 00.00 | - |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | 00.00 | 00.00 | 00.00 | - |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 01.00 | 01.00 | 00.00 | - |
| 610001 | Төсвийн байгууллага | 01.00 | 01.00 | 00.00 | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 30.00 | 30.00 | 00.00 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 00.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 19.00 | 19.00 | 00.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 10.00 | 10.00 | 00.00 | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **305,433.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **305,433.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 305,433.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 305,433.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 305,433.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 305,433.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 305,433.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 305,433.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэбулган сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Ньюбаланс аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Лхагвадорж, аудиторын туслах Д.Балжинням нар гүйцэтгэж, хяналтыг аудитын чанарын менежер Д.Гэрэлчулуун, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Гансүх, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэбулган сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ньюбаланс аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Эрдэнэбулган сумын Хүүхдийн цэцэрлэг нь хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах зорилго дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэбулган сумын Хүүхдийн цэцэрлэгийн  2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлан нийт зардлын  435,1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 8.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу  6.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Эрдэнэбулган сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3.8 сая төгрөгөөр буюу 0.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гараагүй байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 0,0 | 0,0 | |
| Бараа материал | 127.7 | 147.7 | 20.0 |
| Биет хөрөнгө | 657.8 | 641.5 | -16.3 |
| Биет бус хөрөнгө | 14.5 | 14.5 | 0.00 |
| **Нийт хөрөнгө** | **799.9** | **803.7** | **3.8** |
| Хуримтлагдсан үр дүн | 615.0 | 616.2 | 1.2 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **799.9** | **803.7** | **3.8** |

Бараа материалын дансны үлдэгдэл 147.7 сая төгрөг болж 20.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд Урсгал засврын материал, хоолны материал зэрэг бараа авсан нь үлдэгдэл өсөхөд нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 656.0 сая төгрөг болж -16.3 сая төгрөгөөр буурсан нь хөрөнгө оруулалтаар 3.2 сая төгрөг, төсвийн хөрөнгөөр 3.6 сая төгрөгийн хөрөнгө орлого авч, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар 28.7 сая төгрөгийн хөрөнгө актлан данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 801.1 сая төгрөг болж 1.2 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтаар ирсэн хөрөнгийн дүн нөлөөлжээ.

Нийт зардал өмнөх оноос 12.8 сая төгрөгөөр буюу 3.0 хувиар буурсан байна. Энэ нь ковид цар тахалтай холбоотойгоор хүүхдийн хоолны зардал, хангамж бараа материалын зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Эрдэнэбулган сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 435.6 сая төгрөгөөр, нийт зарлагыг 435.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 11.2 төгрөгөөр бууруулж 424.4 сая төгрөгөөр баталсан байна.

Энэ төсвийн жилд батлагдсан төсөвт 2 удаа тодотгол хийж тайлант жилийн нөхцөл байдалтай уялдуулан хүүхдийн хоолны зардлаас 36.1 сая төгрөг хасч, зохицуулалтаар хоолны зардлаас 17.0 сая төгрөг, төрөөс иргэдэд олгох 5.0 сая төгрөг хасч цалин шимтгэлийн зардалд 28.5 сая төгрөгийг нэмж зохицуулалт хийсэн байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Эрдэнэбулган сумын Хүүхдийн цэцэрлэг тайлант оны гүйцэтгэлээр улсын төсвөөс 397.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 17.7 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 414.8 сая төгрөгийг зарцуулж 0.04 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 414.8 сая төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь эд хогшил урсгал засварын зардлаас дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээнд 23,972.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

71801 буюу Сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн хүрээнд 5 зориулалт арга хэмжээнд зарцуулсан гүйцэтгэлийг хүснэгтээр үзүүлбэл :

/сая төгрөгөөр/

| Зориулалт, арга хэмжээний код | Арга хэмжээний нэр | Төсөв | Гүйцэтгэл | зөрүү | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 81834 | Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 226.8 | 226.8 | 0.00 | |
| 81835 | Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах | 149.05 | 149.01 | 0.04 | төвлөрүүлсэн |
| 80109 | ТШЗ ийн байгууллагуудын тогтмол зардал | 17.7 | 17.7 | 0.00 | |
| 81807 | Дотуур байрны хүүхдийн хоол | 21.6 | 21.6 | 0.00 | |
| 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | | | | |
| Дүн | | **610.15** | **610.11** | **0.04** | **төвлөрүүлсэн** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Эрдэнэбулган сумын хүүхдийн цэцэрлэг тайлант онд Аймгийн боловсролын газраас 305.4 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна.

Нэмэлтээр ирсэн санхүүжилтийн 305.4 мянган төгрөгөөр бараа материалын тайланд ариутгагчтай халуун хэмжигч орлого авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус цэцэрлэг нь санхүүгийн тайлангийн толилуулга, тодруулгад онцлох асуудлын талаар мэдээлэл тусгаагүй байна.

Тайлант онд Ковид-19 цар тахлын улмаас цэцэрлэгийн үйл ажиллагаа тасралтгүй байх зарчим алдагдсан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитын явцад үлэмж нөлөө үзүүлэх асуудал үүсээгүй.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 141 мэдээлэлээс хугацаандаа оруулсан 140 мэдээлэл, хугацаа болоогүй 1 мэдээлэл байгаа бөгөөд шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

- Монгол Улсын Засгийн газрын “Үдийн хоолны норматив тогтоох тухай” 2021 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 237 дугаар тогтоолын 1-д “Хүүхдийн цэцэрлэгийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 1500 (нэг мянга таван зуун) төгрөгөөр тогтоосугай.” гэж, 2-д “....6-9 дүгээр ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2022 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс 1800 (нэг мянга найман зуун) төгрөг байхаар тогтоож,...” гэж тус тус заасныг мөрдөн ажилласан байна. Мөн Засгийн газрын “Хоолны зардлын норматив тогтоох тухай” 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 450 дугаар тогтоолын 2-т “Хүүхдийн цэцэрлэгийн дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардлыг 3475 (Гурван мянга дөрвөн зуун далан таван) төгрөгөөр тогтоосугай.” гэж заасныг дагаж мөрдөж байна.
- Тайлант хугацаанд “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн 1 дүгээр зүйл, “Нийгмийн даатгалын тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.7" хувьд өөрчлөлт орж, "11.7" хувь, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.5" хувьд өөрчлөлт орж, "11.5" хувь болж өөрчлөгдсөн.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж, акт , албан шаардлага байхгүй.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар залруулсан алдаа , төлбөрийн акт , албан шаардлага, зөвлөмж байхгүй. Харин дахин үнэлэгдэж орлого авсан хөрөнгийн санхүүгийн тайлангийн дүн болон Аймгийн ИТХ
4.1 Залруулсан алдаа

4.1.1. Аудитын гүйцэтгэлийн шатанд Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө нийт дүн буруу байсныг залруулав.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага тавиагүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Шилэн дансны мэдээлэлтэй Холбоотой асуудал***

*1.1.* ***Илрүүлэлт:*** Шилэн дансанд байршуулсан мэдээллүүд нь хугацаандаа шивж оруулсан боловч мэдээний чанар, гүйцэтгэл муу байна. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 заалтыг хэрэгжүүлэх. Иж бүрэн байх байх батламж мэдэгдлийг зөрчиж байна.

1.2. ***Өгсөн зөвлөмж:*** Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 заалтыг хэрэгжүүлж ажиллах.

***2. Бодлогын баримт бичигтэй холбоотой***

2.1. *Илрүүлэлт:* Байгууллагаас авсан санал асуулга, журналын бичилтээс харахад өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг тусгасан бодлогын баримт бичиг боловсруулж батлуулаагүй байна. Толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*2.2.* *Өгсөн зөвлөмж:* Бодлогын баримт бичгийг шинээр боловсруулж, мөрдөж ажиллах.

***3. Бараа ажил үйлчилгээний баримтын бүрдэлтэй холбоотой***

*3.1.* *Илрүүлэлт:* Баримтыг түүвэрчлэн тулгахад харилцагч байгууллагын нэхэмжлэх, зарлага, орлогын падаан байгаа боловч э-баримтгүй байна. Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.1 *Өгсөн зөвлөмж:* Э-баримт болон бусад баримтын бүрдэл болсон гүйлгээг хийж, зөрчлийг дахин давтахгүй байна.

***4. Үндсэн хөрөнгөтэй холбоотой***

4.1. ***Илрүүлэлт:*** Элэгдлээ бүрэн нөхсөн, 00 үлдэгдэлтэй 44 төрлийн 74 ширхэг үндсэн хөрөнгийн ашиглах жил болон үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.Үнэлгээ ба хувиарлалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. ***Өгсөн зөвлөмж:*** 2022 оны эхний хагас жилд багтаан холбогдох газарт материалыг бүрдүүлэн өгч, тайлан балансад тусгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын сургууль. | 5 | 0.00 | 1 | 0.00 | 0 | 0.00 | 0 | 0.00 | 4 | 0.00 |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС ХЯНАСАН:

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: А.ЭРДЭНЭБААТАР
Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР: Э.БАТ-ЭРДЭНЭ
Огноо:

АУДИТОР С.ГАНСҮХ
Огноо:

НЬЮБАЛАНС АУДИТ ХХК-ИАС ХЯНАСАН:

ЧАНАРЫН МЕНЕЖЕР Д.ГЭРЭЛЧУЛУУН
Огноо:

БОЛОВСРУУЛСАН:
АУДИТОРЫН ТУСЛАХ Д.БАЛЖИННЯМ
Огноо: